



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 10 өдөр

Дугаар A/40

Сүхбаатар сум

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай


Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, 28.2, 28.3, 30.3.2 дахь заалт, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм батлах тухай” 02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлэхэд нийгмийн түншлэгч талуудын хууль ёсны ашиг сонирхлыг тэгш хангах зорилгоор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны явц, үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг дүрэмд заасны дагуу холбогдох газарт хүргүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч/Ц.Рэгзэдмаа/-д үүрэг болгосугай.


3.Энэхүү захирамж шинэчлэн гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны 05 дүгээр сарын 17-ны өдрийн А/176 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

Сэлэнгэ аймгийн Засаг даргын
2021 оны 02 -р сарын 10 -ны өдрийн
А/МО тоот захирамжийн хавсралт



Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн орон тооны бус
зөвлөлийн шинэчилсэн бүрэлдэхүүн

- Дарга: -Аймгийн Засаг дарга
- Зөвлөлийн орлогч дарга: -Аймгийн Засаг даргын Нийгмийн бодлогын
асуудал хариуцсан орлогч
- Нарийн бичгийн дарга: -Аймгийн Хөдөлмөр, халамжийн
үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийн
хэлтсийн дарга
- Гишүүд:
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү,
Төрийн сангийн хэлтсийн дарга
 - Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
 - Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга
 - Аймгийн Ажил олгогч эвлэлийн холбооны
тэргүүн
 - “Сэлэнгэ –Энерго” ОНӨААТҮГ-ын дарга
 - Цагааннуур сумын Үйлдвэрчний эвлэлийн
холбооны дарга
 - Шаамар сум дахь Мэргэжлийн сургалт
үйлдвэрлэлийн төвийн захирал
 - Ажил олгогч эздийн холбооны гишүүн